

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

№ ХЭХ 01/2026

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Компанийн 2025 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлан баталж, дүрэм
батлах тухай

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.9, 62.1.15 дэх хэсгүүд, 63 дугаар зүйл, 69 дүгээр зүйл, “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.8 дах заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ТУЗТ 04/2026 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар аудит хийгдсэн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
3. Компанийн шинэчилсэн дүрмийг хавсралтаар баталсугай.
4. Компанийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын 12.00 цагт <https://meet.google.com/ydt-kwea-jon> байхаар зарлан хуралдуулсан видео бичлэгийг хадгалсугай.



/Т. ЗОЛБОО/

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

№ ХЭХ 02/2026

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Охин компани нэмж хувьцаа гаргах,
сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх
тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2, 92.3 дахь хэсэг, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ТУЗТ 04/2026 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Шонхор дронс” ХХК нь 1(нэг) бүр нь 1(нэг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 180'000'000 (нэг зуун наян сая) ширхэг буюу 180'000'000 (нэг зуун наян сая) төгрөгийн энгийн хувьцаа гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Компани “Шонхор дронс” ХХК-ийн нэмж гаргасан энгийн хувьцаанаас компанид ноогдох өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ эдлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
3. “Шонхор дронс” ХХК-ийн энгийн хувьцаа нэмж гаргах хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Ган-одыг оролцуулсугай.

ХУРЛЫН ШИЙДВЭР



/Т. ЗОЛБОО/